

ЦАГДААГИЙН БАЙГУУЛЛАГААС ОЛОН НИЙТИЙН АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ ХАНГАХАД ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙГ НЭВТРҮҮЛЭХ АРГА ЗАМ

Д.БУЛГАН. ХСИС-ийн Цагдаагийн сургуулийн Цагдаагийн
эрх зүйн тэнхимийн багш, хууль зүйн магистр, цагдаагийн хошууч

Удиртгал. Дэлхийн улс орны аюулгүй байдлыг хангах үйл ажиллагаа нь аюул тохиолдсоны дараа хор уршгийг арилгах, сэргээн босгох арга хэмжээнд анхаарлаа хандуулдаг байсан бол орчин үеийн аюулгүйжүүлэх үзэл баримтлалд учирч болох эрсдэлийг урьдчилан тодорхойлж, түүнийг бууруулах, түүнд тохирсон арга хэмжээ авч хэрэгжүүлэх замаар аюулаас урьдчилан сэргийлж, нийгмийн аюулгүй байдлыг хангаж улс орны хөгжилд дэмжлэг болдог.

Аюулгүй байдлын онол, арга зүйд томоохон өөрчлөлт гарч, аюулгүй байдлыг хангах үндсэн үйл ажиллагаа бол аюулын чиг хандлагын судалгаа, дүн шинжилгээ хийх явдал буюу эрсдэлийн үнэлгээний асуудал юм. Энэ нь аюулгүй байдалд заналхийлж буй аюулын хэлбэрийн агуулга, шинж чанар өөрчлөгдөх, шинэчлэгдэх, шилжих зэрэг үйл явцыг мэдэхийн тулд заналхийлж буй хэлбэрүүдийг олж тогтоох үйл явц юм.

Цагдаагийн байгууллагын олон нийтийн аюулгүй байдлыг хангах үйл ажиллагаанд аюулыг илрүүлэх, ирээдүйн эрсдэлийг зөв тодорхойлж, түүнд тохирсон шийдвэр гаргах нь цагдаагийн байгууллагын удирдлагуудын хувьд чухал асуудлын нэг юм. Тиймээс цагдаагийн байгууллагын олон нийтийн аюулгүй байдлыг хангах үйл ажиллагааг боловсронгуй болгох, арга замыг тодорхойлохыг зорилоо.

Цагдаагийн байгууллагаас олон нийтэд тулгарч буй аюул, эрсдэлийн үнэлгээ хийх нарийвчилсан эрх зүйн зохицуулалт одоогийн байдлаар хангалттай байхгүй байгаа нь энэ ажлын үр дүн харагдахгүй байгааг илтгэж байна.

Засгийн газрын 2014 оны 79 дүгээр тогтоол “Цагдаагийн байгууллагын хөгжлийн хөтөлбөр”-ийн 5.1.1-д “байгууллагын үйл ажиллагаанд гүйцэтгэлийн болон эрсдэлийн удирдлагын тогтолцоог нэвтрүүлэх” гэж заасан.

Мөн цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны үр дүнд үнэлгээ хийхтэй холбоотой Цагдаагийн ерөнхий газрын даргын 2014 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн 842 дугаар тушаалаар “Цагдаагийн байгууллагын хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх журам” батлагдсан. Энэхүү журмаар цагдаагийн байгууллагын зорилго, зорилт, бодлогын баримт бичиг, эрх зүйн акт, удирдлагын шийдвэр, төлөвлөгөөний хэрэгжилт, үйл ажиллагааны явц, үр дүнд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхтэй холбоотой харилцааг зохицуулахаар тусгасан.

Гамшгаас хамгаалах талаар төрөөс баримтлах бодлогийн үндсэн чиглэлийн хоёрдугаарт “Байгалийн болон хүний хүчин зүйл, техникийн гаралтай гамшгийн төрөл тус бүрээр эрсдэлийн үнэлгээ хийж, гамшгийн эмзэг байдлыг бууруулах ажлыг үндэсний хэмжээнд зохион байгуулна¹” гэж тусгасан.

Үүнтэй холбоотой гамшиг судлалын хүрээлэнгээс “Гамшгийн эрсдэлийн үнэлгээний аргачлал” боловсруулсан бөгөөд гамшгийн хор уршгийг үндэслэн шалгуур үзүүлэлтийг тогтоосон Засгийн газрын 2015 оны 286 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар “Сэрэмжлүүлэх болон урьдчилан сэргийлэх мэдээнд орох ус цаг агаарийн аюултай болон гамшигт үзэгдлийн

¹ Монгол Улсын Их Хурлын 2011 оны 22 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт. Гамшгаас хамгаалах талаар төрөөс баримтлах бодлого <http://www.legalinfo.mn/annex/details/3371?lawid=5909>

жагсаалт”-ыг гаргажээ. Мөн гамшгийн шалгуур үзүүлэлтийг тогтоох талаар гамшиг судлалын хүрээлэнгийн судлаачид судалгаа² хийжээ.

“Гамшгийн эрсдэлийн үнэлгээний аргачлал³” гарын авлагад эрсдэлийн үнэлгээ нь нэгд, гамшигт үзэгдэл, тэдгээрийн төрөл, магадлал өндөртэйг тогтоох, хоёрт, гамшгаас хамгаалах арга хэмжээг төлөвлөх, хэрэгжүүлэх, гуравт, гамшгаас хамгаалах чадавхийг бэхжүүлэх, үндэслэлийг тавихад чиглэсэн шинжлэх ухааны мэдээлэл, мэдлэгийг бий болгодог үйл явц юм. Гамшгийн эрсдэлийн үнэлгээ нь аюулын үнэлгээ, эмзэг байдлын үнэлгээ, болон чадавхийн үнэлгээ гэсэн 3 төрлийн үнэлгээнээс бүрддэг гэжээ. Энэхүү гарын авлагад үерийн эрсдэлийг үнэлэх, газар хөдлөлтийн эрсдэлийг үнэлэх, химийн ослын эрсдэлийн үнэлгээний, гал түймрийн эрсдэлийн үнэлгээ хийх гэх мэт олон аргачлал боловсруулжээ.

Харин байгалийн гаралтай аюулаас бусад аюул, занал, эмзэг байдлын талаарх эрсдэлийн үнэлгээ хийхтэй холбоотой судалгааны ажил, аргачлал төдийлөн байхгүй гэж хэлж болно. Тухайлбал цагдаагийн байгууллагаас нийтийг хамарсан арга хэмжээний үед эрсдэлийн үнэлгээ хийх, аргачлал боловсруулж, үйл ажиллагаандаа хэрэгжүүлэх шаардлагатай юм.

Цагдаагийн байгууллагын олон нийтийн аюулгүй байдлыг хангах үйл ажиллагаанд аюулын эрсдэлийн үнэлгээ хийхтэй холбоотой судалгааны ажил хомс байна.

Эрсдэлийн үнэлгээний онолын үндэслэл. “Эрсдэл”-ийн талаарх ойлголт 15-р зуунаас хойш хөгжсөн бөгөөд эдийн засгийн үйл ажиллагаан дахь даатгалтай холбогдож үүссэн. Энэ ойлголт нь магадлалын онол, эдийн засаг болон шийдвэр гаргах онолд өргөн цар хүрээгээр ашиглагддаг байв. 1970 оноос хойш энэхүү үзэл баримтлал нь эрчимтэйгээр эдийн засаг, сэтгэл судлал, социологи, улс төр, нийгмийн шинжлэх ухаанд хэрэглэгдэж эхэлсэн⁴.

XX-р зууны сүүлчээр аж үйлдвэрлэл хөгжиж нийгэмд шинэ эрсдэлүүд нэмэгдсээр байгаа бөгөөд үүнд байгалийн болон хүний гаралтай аюулуудыг дурдаж болно. Тухайлбал цар тахал, САРС өвчин (SARS), газар хөдлөлт, үер, хар шуурга, терроризм, хүний наймаа, хар тамхины худалдаа, кибер гэмт хэрэг, үзэл суртлын зөрчилдөөн, терроризм гэх мэт аюулуудыг хэлж болно.

Аюул, заналхийлэл болон тэдний нөхцөл байдал, нөлөөлөл нь өөр өөр байдаг бөгөөд түүнд тохирсон үр дүнтэй арга бол эрсдэлийг тодорхойлох явдал юм. Олон улсад аюул, эрсдэлийг тодорхойлох, үнэлэх, тэдэнд хяналт тавих замаар эрсдэлийг ойлгох, түүнд тохирсон үр дүнтэй арга хэмжээ хэрэгжүүлэх нь чухал алхам юм гэдгийг хүлээн зөвшөөрч, ISO 31000: 2009⁵ эрсдэлийн менежментийн олон улсын стандартыг бий болгосон.

Эрсдэлийн менежмент⁶ (risk management) гэдэг нь ISO 31000:2009 эрсдэлийн удирдлагын хэм хэмжээ буюу удирдамжид суурилсан, шийдвэр гаргагчийн цогц үйл явцаар шатлан хэрэгждэг үйл ажиллагаа юм.

Олон нийтэд тулгарч буй аюулыг эрт илрүүлэх, даван туулах, дүн шинжилгээ хийж, боломжийн үр дүнг хүртэх, алсыг харсан бодлого боловсруулахад эрдэлийн менежмент⁷ нь

² С. Хүрэлсүх, З.Баттулга. Гамшгийн цар хүрээний ангилал, эрсдэлийн түвшин, зэрэглэл тогтоох арга зүйн судалгаа. ГСХ-ийн Судалгааны ажлын эмхэтгэл, -УБ, 2010 он. Д.Сэржмядаг нар. Монгол орны нөхцөлд тохирсон гамшгийн шалгуур үзүүлэлт тогтоох асуудалд. Судалгааны ажлын эмхэтгэл. –УБ, 2015., 200 дахь тал.

³ Гамшгийн эрсдэлийн үнэлгээний аргачлал. –УБ, 2012. Гамшиг судлалын хүрээлэн. 1 дэх тал.

⁴ H.G. Brauch et al. (eds.), *Coping with Global Environmental Change, Disasters and Security*, Hexagon Series on Human 61 and Environmental Security and Peace 5, DOI 10.1007/978-3-642-17776-7_2, © Springer-Verlag Berlin Heidelberg 2011

⁵ ISO 31000:2009 Risk management-Principles and guidelines. http://www.iso.org/iso/catalogue_detail?csnumber=43170

⁶ Silja Meyer-Nieberg, Stefan Pickl, Martin Zsifkovits. Operations Research for Risk Management in Strategic Foresight. 2015. <https://planet-risk.org/index.php/pr/article/view/219>

чухал ач холбогдолтой бөгөөд дараахь ерөнхий үе шатыг дамждаг. Үүнд: нэгд, хэтийн төлөв, чиг хандлагыг тодорхойлох; хоёр дахь үе шат нь мэдээлэл дээр үндэслэн ирээдүйн боломжит хөгжлийн талаар таамаглал хийх, гурав дахь үе шатанд ирээдүйн талаар боломжит магадлалын талаар дүн шинжилгээ хийж, бодлого боловсруулах бололцоотой болдог.

Эрсдэлийн менежмент нь нийтийн эрх зүйн хүрээнд шийдвэр гаргах болон эрсдэлийг хянахад чиглэсэн системтэй үйл явц бөгөөд аюулыг илрүүлж, ирээдүйн эрсдэлийг тодорхойлж, түүнд тохирсон үйл ажиллагаагаа хэрэгжүүлэх гэсэн ойлголтоор илэрхийлэгддэг.

Цагдаагийн байгууллагын олон нийтийн аюулгүй байдлыг хангах үйл ажиллагаанд эрсдэлийн менежментийг бодит утгаар нь хэрэгжүүлэхийн тулд эрсдэлийн менежментийн стандарт, зарчим, үйл явц, техникийг нэвтрүүлэх шаардлагатай юм. Ингэснээр шийдвэр гаргах үйл явц системтэй албан ёсны болохоос гадна эрсдэлийг бууруулахад оролцогч бүх талууд нэгдмэл ойлголттойгоор харилцаж, хамтран ажиллах давуу тал бий болно.

Олон улсад хэрэглэгдэж буй эрсдэлийн менежмент⁸ нь дараахь үйл явцыг агуулж байдаг. Үүнд:

1. Эрсдэлийн үнэлгээний орчинг бий болгох- Эрсдэлийн үнэлгээ хийхтэй холбоотой мэдээлэл цуглуулах явц.
2. Эрсдэлийн тодорхойлох - эрсдэлийг хүлээн зөвшөөрөх, тодорхойлох ба эрсдэлийг бүртгэх үйл явц.
3. Эрсдэлийн шинжилгээ - эрсдэлийн магадлал, нөлөөллийн мөн чанар, эрсдэлийн түвшинг тогтоох процесс.
4. Эрсдэлийн үнэлгээ - эрсдэл байгаа эсэхийг тодорхойлсон шалгуурыг эрсдэлийн шинжилгээний үр дүнг харьцуулан үзэх үйл явц
5. Эрсдэлийг бууруулах – эрсдэлд хяналт тавих, эрсдэлийг бууруулах арга хэмжээг санал болгох

⁷ Habegger, B. Strategic foresight in public policy: Reviewing the experiences of the UK, Singapore, and the Netherlands, Futures 42, 2010, pp. 49–58.

⁸ All Hazards Risk Assessment Methodology Guidelines 2012-2013. <https://www.publicsafety.gc.ca/cnt/rsrscs/pblctns/ll-hzrds-sssmnt/index-en.aspx>



Эндээс харахад эрсдэлийн менежментийн үйл явц нь олон нийтэд тохиолдох аюул, заналыг тодорхойлж, өртөх объектыг хамгаалах чадавх, аюул, занал, эрсдэлийг бууруулах арга замын талаар мэдээлэл өгдөг учраас шийдвэр гаргагчид эрсдэлийг бууруулах, хянах хамгийн тохирсон арга замыг олоход дэмжлэг үзүүлдэг арга хэрэгсэл юм. Тиймээс ч эрсдэлийн менежмент нь цагдаагийн байгууллагын олон нийтийн аюулгүй байдлыг хангах үйл ажиллагаагаа амжилттай хэрэгжүүлэх арга хэрэгсэл, үндэс суурь болно.

Тиймээс эрсдэлийн үнэлгээ хийх үе шатыг тодорхойлж дэлгэрүүлэн авч үзье.

1-р алхам: Эхний алхам нь байгууллагын стратегийн болон үйл ажиллагааны хүрээнд иж бүрэн мэдээллийг боловсруулах явдал юм. Засгийн газрын байгууллагууд холбогдох хууль тогтоомж, төлөвлөгөө, тайлан гэх мэт холбогдох мэдээ, мэдээлэл цуглуулж, судалж үзэх хэрэгтэй. Энэ үед мэдээллийн олон эх үүсвэрийг судалж, хянаж болно.

Эдгээр мэдээллийн эх сурвалжаас эрсдэлийн загвар, эрсдэлтэй холбоотой үйл ажиллагаа, үзэгдлийг тодорхойлоход чухал ач холбогдолтой. Ийнхүү эрсдэлийн жагсаалтыг гаргаснаар дараагийн шатанд анхаарлаа хандуулах зорилгоор боловсруулна.

Энэ алхамын зорилт нь аюул ослын бүртгэл хийхийн тулд хамааралтай өгөгдлийг аль болох өргөн хүрээнд цуглуулж бүтцэд оруулах юм. Аюул ослын бүртгэл нь ирээдүйд тулгарч болох аюул заналхийллийг харуулна. Ялангуяа үндэсний аюулгүй байдлын салбарт тоон ба чанарын аргуудыг ашиглах нь сонирхлын хамрах хүрээг олж мэдэхэд тустай байдаг.

Эрсдэлийн үнэлгээг хугацааны хувьд:

- Богино хугацааны аюулын дүн шинжилгээ хийж тодорхойлж болно. Энэ нь 5 жилийн хугацааны эрсдэлийн дүн шинжилгээ байна.
- Урт хугацааны болон 5-25 жилийн хугацаанд дахь ирээдүйн эрсдэлийн дүн шинжилгээ хийж болно. Ингэхдээ янз бүрийн арга, арга хэрэгсэл хэрэглэж болно.

2-р алхам: Эрсдэлийн тодорхойлох нь эрсдэлийн үнэлгээний үйл явцын нэг гол бүрэлдэхүүн хэсэг болно. Энэ нь эрсдэлийг тодорхойлох, олох, хүлээн зөвшөөрч, эрсдэлийг бүртгэх үйл явц юм. Гол нөлөө үзүүлж байгаа эрсдэлүүдийг тодорхойлох явдал шаардлагатай.

Эрсдэлийг тодорхойлоход нэг дэх алхамын үед хийгдсэн богино болон урт хугацааны эрсдэлийн жагсаалт шаардлагатай болдог. Өөрөөр хэлбэл шийдвэр гаргагчийн дараагийн алхам нь өмнөх шатанд хийгдсэн өгөгдлүүд дээр үндэслэн ирээдүйд хийх ажлын төлөвлөгөөг

боловсруулах явдал юм. Хийх ажлын төлөвлөгөө нь өргөн хүрээг хамарсан судалгаанд суурилсан байх ёстой. Түүнчлэн шаардлагатай шалгуур үзүүлэлтүүдийн дагуу зэрэглэлийг тогтооно. Зэрэглэл нь тодорхой бус зүйл тохиолдох магадлал, нөлөөллийн зэргийг авч үздэг.

3-р алхам: Эрсдэлийн шинжилгээ. Эрсдэлийн үнэлгээний зорилго нь эрсдэл үүссэний дараахь нөхцөл байдлын таамаглалуудын мөн чанарыг тодорхойлоход оршино. Эдгээр мэдээлэлүүд нь эрсдэлийн үнэлгээний суурь болох бөгөөд цаашлаад эрсдэлийн арга хэмжээг оновчтой тодорхойлох үндэс болдог.

Эрсдэлийн шинжилгээнд дараахь ажлууд хийгддэг

- Нөхцөл байдлын таамаглал болон магадлалын шинжилгээ
- Эрсдэлт нөхцөл байдлын дараахь нөлөөллийн шинжилгээ

Нөхцөл байдлын таамаглалын/магадлалын шинжилгээ. Эрсдэлтэй нөхцөл байдал ямар үед үүсэхийг таамаглах шинжилгээ юм. Математик хувьсагч ашиглан энэ магадлалыг тодорхойлж болдог. Үүсэх эрсдэлтэй нөхцөл байдал нь заналхийлсэн байх эсвэл санаандгүй байдлаар үүссэн байхыг үл хамааран эрсдэл үүсэх магадлалыг хэзээ ч хайхралгүй орхиж болохгүй юм.

Эрсдэл үүсэх магадлалыг хүлээн зөвшөөрөх нь цаашдаа тухайн нөхцөл байдал үнэхээр үүсвэл ямар арга хэмжээ авах хэрэгтэйг тооцолох үндэс болно. Энэ таамаглалыг тоон болон чанарын гэсэн хоёр аргаар тодорхойлох боломжтой.

Нөхцөл байдлын таамаглалыг тоон аргаар тооцолохдоо детеминацийн тооцоолол хийх буюу загварчилах эсвэл магадлалыг тодорхойлж болно. Магадлалыг тодохойлох нь өнгөрсөн үеийн мэдээлэлүүд дээр тулгуурладаг тул илүү бодитой байдаг. Харин өнгөрсөн үеийн мэдээлэл байхгүй, дамтамжтай үүсэх боломжгүй эрсдлүүдийг (терроризм, хувь хүний заналхийлэх г.м) тоон аргаар тооцоолох боломжгүй тул мэргэжлийн шинжээчдийн дүгнэлтээр хийгдэнэ. Энэ тохиолдолд нөхцөл байдлын хувьсагчуудыг тодорхойлж үнэлэх байдлаар цаашдын дүгнэлтэд хүрдэг. Хэдийгээр мэргэжлийн шинжээчдээс туслалцаа авч байгаа боловч тодорхой суурь мэдээлэл байхгүй тул тодорхойгүй байдалтай хэвээр үлддэг.

Нөлөөлөлийн шинжилгээ. Ямар ч эрсдэлтэй нөхцөл байдал үүсэхэд заавал ямар нэгэн гарз гардаг. Эрсдэлтэй байдал үүсэх боломжтой эсэхийг туршилт хийж, өнгөрсөн үеийн мэдээлэл ашиглаж, эсвэл эрсдэл бүрийн дараа гарах магадлалтай гарзыг тоон аргаар тооцоолж гаргаж болно. Нэн түрүүнд эрсдэлт нөхцөл байдалд үүссэний дараахь гарзыг тодорхойлохдоо дараах асуултуудыг асуух шаардлагатай байдаг.

- Тухайн эрсдэл нь өргөн хэмжээний газар нутгийг хамрах магадлалтай байна уу?
- Тухайн эрсдэл нь хүн амын эрүүл мэндэд нөлөөлөх магадлалтай юу?
- Тухайн эрсдэл нь хилийн зурваст нөлөөлөх магадлалтай юу?
- Тухайн эрсдэл нь хүрээлэн буй орчинд урт хугацаанд нөлөөлөх магадлалтай юу? гэх мэтээр асуултыг тухай нөхцөл байдалд тохируулж тавьна.

Гарах гарзуудыг мөнгөн, техникийн, үйл ажиллагааны, нийгмийн, хүний гэсэн төрлүүдэд ангилж болно.

Нөлөөллийн шинжилгээ нь дараахь алхамуудаар хийгддэг.

1. Эрсдэлтэй нөхцөл байдлын дараа үүсч болох бүхий л гарз, хохирлыг тодорхойлох,
2. Эдгээр хохирлуудыг тодорхой төрлүүдэд хувааж ангилж болно,
3. Бүх гарзыг үнэлэх,

4. Гарз тус бүр үүсэх хэдэн хувийн магадлалтайг тодорхойлох, тооцоолох гэх мэт.

Нөлөөлөлийг үнэлэх арга. Эдгээр гарч болох гарз хохирлыг үнэлж, аль нь хамгийн аюултайг тодорхойлох нь чухал үйл ажиллагаа юм. Ингэснээр хамгийн их хор уршигтай хохирлоос урьдчилан сэргийлэх боломжтой болно.

Нөхцөл байдлын таамаглалын/магадлалын шинжилгээ болон нөлөөлөлийн шинжилгээний итгэх түвшин

Гарзын ангилал тус бүрийг тоогоор үнэлж байгаа нь итгэх түвшинг илэрхийлнэ. Итгэх түвшинд А-с Е хүртэл зэрэглэл тогтоодог. Өмнөх жилүүдийн мэдээлэл, тоон өгөгдөл, урьд жилүүдийн туршлага зэргээр итгэх түвшингийн зэрэглэл тодорхойлогддог. Энэ үйл ажиллагааны үр дүнд бий болсон мэдээлэлээс цаашдын алхамуудыг хийх боломжтой болдог тул хамгийн чухал алхам юм. Хэрэв итгэх түвшин бага бол эрсдэл байдал үүсэхэд тооцоологдоогүй өөр хохирол бий болох магадлалтай эсвэл тооцоолсоноос илүү их хэмжээний гарз хохирол амсах магадлалтай гэсэн үг. Харин итгэх түвшин маш өндөр бол эрсдэлтэй нөхцөл байдал үүсэхэд яг ямар арга хэмжээ авах шаардлагатайг тооцоолох боломжтой болно.

4-р алхам: Эрсдэлийн үнэлгээ. Эрсдэлийн үнэлгээ гэдэг нь эрсдэлийн шинжилгээний үр дүнг эрсдэлийн хязгаартай харьцуулах үйл ажиллагаа юм. Эрсдэлийн хязгаар гэдэг нь хүний даван туулж болох эрсдэлийн дээд хязгаарыг хэмжсэн үзүүлэлт юм. Эрсдэлийг үнэлсэнээр аль эрсдэлд нэн түрүүнд арга хэмжээ авах хэрэгтэй болохыг тодорхойлох, эрсдэлүүдийг арга хэмжээ авах шаардлагатай дарааллаар нь жагсаах боломжтой болдог.

Эрсдэлийг үнэлэх үйл ажиллагаанд дараахь мэдээллүүд шаардагдана.

- Эрсдэл гарч болох нөхцөл байдал, эрсдэл үүсэхэд нөлөөлсөн байж болох бүхий л аюулыг хангалттай хэмжээний итгэлцлийн түвшингээр баталгаажуулсан байх
- Эрсдэлээс үүдэн гарч болох анхдагч аюулыг тодорхойлж, хангалттай хэмжээний итгэлцлийн түвшингээр баталгаажуулсан байх
- Эрсдэлээс үүдэн гарч болох нийт аюулыг тодорхойлж, хангалттай хэмжээний итгэлцлийн түвшингээр баталгаажуулсан байх
- Нэмэлт мэдээлэл болгож эрсдэлийн шинжилгээний үр дүнд үүссэн бусад мэдээллийг ашиглана.

5-р алхам: Эрсдэлийг бууруулах арга хэмжээ. Энэ нь эрсдэлийг удирдах аргыг боловсруулах, сонгох болон түүнийг хэрэгжүүлэх үйл явцын цогц юм. Эрсдэлийн арга хэмжээг эрсдэлийн шинжээчийн зүгээс эрсдэлийн дүгнэлт болон бусад хүчин зүйлс дээр тулгуурлан эрсдэлийн арга хэмжээг зөв боловсруулахыг санал болгох болно. Эдгээр санал болгосон зүйлс нь эрсдэлийн менежерүүд болон шийдвэр гаргагчдад эрсдэлийн арга хэмжээний томъёоллыг зөв гаргахад туслах юм.

Эрсдэлийн арга хэмжээнд дараахь зүйлс багтдаг. Үүнд:

- Эрсдэл үүсэх магадлалтай үйл ажиллагаанаас зайлсхийх, анхнаасаа эрсдэлтэй зүйл хийхгүй байх
- Эрсдэлийг үүсгэх хүчин зүйлсийг зохицуулах
- Эрсдэл үүсэх гол шалтгааныг устгах
- Сөрөг үр дагаварыг устгах
- Бусад байгууллага, холбогдох хүмүүст эрсдэл үүсэх магадлалтайг мэдээлэх

- Эрсдэл үүсэх хугацааг хойшлуулах гэх зэрэг арга хэмжээ авч болох ба эдгээрээс оновчтой бусад хувилбарууд ажиглагдвал хэрэгжүүлнэ.

Аюул ослыг илрүүлсэн, анализ хийгдсэн, холбогдох хийх ажлын төлөвлөгөө нь боловсруулагдсаны дараа эрсдэлийн удирдлагын хэрэгслийн хамгийн сүүлийн алхам нь үнэлгээний процесс байдаг. Түүнчлэн өмнөх алхмуудад хийгдсэн суурь өгөгдөл, ололт үр дүн зэргийг үндэслэн анализын ямар хандлагыг ашиглах вэ гэсэн шийдвэртэй тулгардаг. Бүх хийх ажлын төлөвлөгөөг хэрэгжүүлэх боломжтой цор ганц хандлага байх боломжгүй. Тиймээс хийх ажлын төлөвлөгөө бүрт тохирсон үнэлгээний аргачлалыг олж тогтоох нь чухал. Үнэлгээний үе шатанд статистик тест хийх, системийн динамик загвар гаргах, агентад тулгуурласан загвар гаргах, логик анализ нь эрсдэлийн үнэлгээг хийхэд олон талт аргачлал/хандлагыг ашиглах нь үндэс нь болдог байна.

Эрсдэлийн үнэлгээний үйл ажиллагаа тогтмол хийгдэх гол шалтгаан нь мэдээллийн хүрэлцээгүй байдал, өгөгдлийн менежментийн дутагдалтай байдал зэргээс үүсдэг. Ялангуяа эрсдэлийг бууруулах арга хэмжээ авч байгаа үед эрсдэлийн түвшин үнэхээр буурч байгаа эсэхийг жил жилүүдийн тоон мэдээлэл нотолж чадна. Эрсдэлийн үнэлгээтэй холбоотой жил жилийн мэдээллийг хийгдсэн бүхий л үйл ажиллагаатай хавсарган хадгалж, тоон мэдээллүүдийг нөөцлөх хэрэгтэй юм. Ингэхдээ, стандартчилагдсан хүснэгтэн маягт хэлбэрээр эсвэл тус стандартад өгөгдсөн бусад хэлбэрээр мэдээллийг бүртгэдэг.

Цагдаагийн байгууллагаас нийтийг хамарсан арга хэмжээний үеийн хамгаалалтын төлөвлөгөө боловсруулахад зайлшгүй эрсдэлийн үнэлгээ хийгдэх бөгөөд хамгаалалтын төлөвлөгөө нь 1-т үйл явдлыг амжилттай зохион байгуулах, 2-т эрсдэлийг бууруулах, гаргуулахгүй байх нөхцөлийг бүрдүүлэх зорилготой хийгддэг юм.

Дүгнэлт. Цагдаагийн байгууллагаас олон нийтийн аюулгүй байдлыг хангах үйл ажиллагаанд эрсдэлийн үнэлгээ хийх эрх зүйн зохицуулалт, зохион байгуулалт болон арга зүй, аргачлалыг боловсронгуй болгох нь зүйтэй.

Эрх зүй, зохион байгуулалтын хувьд цагдаагийн байгууллагаас чиг үүргээ хэрэгжүүлэхдээ эрсдэлийн үнэлгээ хийх талаар нарийн зохицуулалтыг бий болгох, эрсдэлийн үнэлгээ хийх ажлын хэсэг байгуулах, энэ нь мэргэшсэн шинжээчдээс бүрдэх зэрэг зохион байгуулалтын арга хэмжээг авч хэрэгжүүлэх хэрэгтэй байна.

Арга зүйн хувьд цагдаагийн байгууллагаас олон нийтийн аюулгүй байдлыг хангах үйл ажиллагаанд эрсдэлийн үнэлгээ хийх аргачлал, загварыг бий болгох талаар судалгааны ажлыг эрчимжүүлж, хийх нь зүйтэй юм. Гэхдээ бүхий л тохиолдолд тохирсон аргачлал боловсруулах боломжгүй юм. Тиймээс цагдаагийн байгууллагын олон нийтийн аюулгүй байдлыг хангах чиг үүрэг, үйл ажиллагааны төрөл тус бүрээр ангилж боловсруулж болох юм.